

# СОЁМБОМЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.07.05 №88(88)

## АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦЫГ ЗХЖШ-ЫН УДИРДЛАГА ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛНЭ



Ховд аймгийн Буянт сумын харьяат, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховдоос Улаанбаатар хот хүртэл 1500 километр зайд гүйхээр 2021 оны зургаадугаар сарын 2-ны өдөр гараанаас гарсан. Тэрээр 33 дахь өдрөө гүйж, Улаанбаатар хотод өчигдөр өглөө ирсэн юм. Э.Даваажамц долоодугаар сарын 10-ны өдөр буюу Монгол Улсын "Төрийн далбааны өдөр"-т зориулсан цэргийн ёслолын жагсаалын үеэр Улаанбаатар хот, Сүхбаатарын талбайд барианд орохоор тооцолсон боловч, Үндэсний баяр наадам хойшилсон тул үргэлжлүүлэн гүйж, Дорнод аймагт хүрэхээр төлөвлөөд байгаа юм. Түүнийг Улаанбаатараар дамжин өнгөрөх явцад буюу өнөөдөр ЗХЖШ-ын удирдлага хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
өдөр	шөнө
☀️ 22	🌙 11
ӨМӨНД СУДАН	
өдөр	шөнө
☀️ 33	🌙 22

ВАЛЮТЫН ХАНШ		
Валют	Авах	Зарах
USD 🇺🇸	2.851.00	2.853.00
EUR 🇪🇺	3.375.00	3.95.00
CNY 🇨🇳	441.00	442.00
RUB 🇷🇺	38.40	40.10
JPY 🇯🇵	25.36	25.84
KRW 🇰🇷	2.43	2.57

**ЗУХАЙ**  
**АРГЫН ТООЛЛЫН:**  
 2021.07.05, ДАВАА ГАРАГ

**ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХ БАР ӨДӨР**

**НАРАН УРГАХ ШИНГЭХ:**  
 05.00-20.54

**ҮС ЗАСУУЛБАЛ:**  
 ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ

**БАРИЛДЛАГА:**  
 Үхэх

**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**  
 Хурьцахуй

Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, харал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

## "ABU-ROBOCON 2021" ҮБХИС-ИЙН РОБОТ ТЕХНИК ЗОХИОН БҮТЭЭГЧ "АРАВТ" БАГ ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА



"ABU-Robocon" /Robot contest/ тэмцээн 20 дахь жилдээ зохион байгуулагдаж байна. Холбооны гишүүн орнууд тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулж аварга багийг шалгаруулдаг ба Монгол Улсын "ABU-Robocon 2021" Үндэсний аварга шалгаруулах роботын тэмцээнийг Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Үндэсний батлан хамгаалахын их сургууль хамтран зохион байгуулсан юм.

Тэмцээн энэ сарын 2-ны өдөр ҮБХИС-ийн "Алтан-Илд" спорт цогцолборт цахим хэлбэрээр зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд аваргын төлөө ҮБХИС-ийн "Аравт" баг, ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн "Цахим алт" багууд таарч өөрсдийн зохион бүтээсэн роботоор дүрэмд заасан даалгаврыг гүйцэтгэж өрсөлдсөнөөс ҮБХИС-ийн "Аравт" баг дэд байрт шалгарч ШУТИС-ийн МХТС-ийн "Цахим алт" баг тэргүүн байрын эзэн болов.

"Аравт" багийн хувьд удирдагч багш, сонсогч, оюутнууд цэргийн ба тусгай зориулалтын робот техник зохион бүтээх чиглэлээр судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн юм. Түүнчлэн тэмцээний агуулга нь МЭӨ 770-476 оны үед Хятад улсад гаднын улс орноос ирсэн зочдоо цэнгүүлэхээр "Саванд сум харвадаг" уламжлалт тоглоомыг тоглуулдаг байжээ. Энэ ёслол уламжлалаас сэдэвлэн энэ жилийн "Робокон 2021" дүрмийг боловсруулсан төдийгүй тоглолт үргэлжлэх 3 минутын хугацаанд оюутан залуус хийж бүтээснийхээ үр шимийг харуулдаг аж.

Сонирхуулахад энэ жилийн Үндэсний аварга баг Монгол Улсаа төлөөлөн БНХАУ-ын Жумод болох Олон улсын Робокон тэмцээнд оролцох эрхтэй бөгөөд тус тэмцээнийг МҮОНРТ албан ёсны эрхтэйгээр зохион байгуулж эхлэснээс хойш 6000 гаруй оюутан залуус оролцжээ.

Ази Номхон далайн орнуудын өргөн нэвтрүүлгийн холбоо /Asia Pacific Broadcasting Union/-оос жил бүр уламжлал болгон зохион

байгуулагддаг гишүүн орнуудын оюутан залуусын хамтын ажиллагаа, бүтээлч сэтгэхүй, мэргэжлийн цогц чадамжийг нэмэгдүүлэх зорилготой

## ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд Залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг хангах, Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд Залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан "Гэр бүлийн боловсрол олгох" цуврал цахим сургалтад Агаарын цэргийн командлал болон Зэвсэгт хүчний 065, 303, 325, 337,

353 дугаар ангийн бие бүрэлдэхүүн хамрагдаж номын дуу сонслоо. Тус сургалт нь "Гэр бүлийн харилцаа", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах, зөвлөгөө өгөх" зэрэг сэдвээр явагдсан нь эцэг эхчүүд, хүүхэд, гэр бүлтэйгээ ажиллахад дэмжлэг болох, мэргэжилтнүүдээс зөвлөгөө, тусламж авах, асуудлаа шийдвэрлэж сурах гэх мэт үр дүнтэй сургалт боллоо.



**МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ**

НИЙТ БҮРТГЭГДСЭН 125.260	ЭДГЭРСЭН 84.819	НАС БАРСАН 617/8
НИЙТ БАТЛАГДСАН 3527 (59)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 349	ЭДГЭРСЭН 3119

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол Нийт: 183,647,224
Эдгэрсэн Нийт:
Нас барсан Нийт: 3,973,847

**119 ТУСГАЙ ДУГААРТ ИРСЭН ИРГЭДИЙН АСУУЛТ БА ХАРИУЛТ**

Ямар төлөвлөлтөд 14 өдөр гурван тусгаарлах вэ?

(Ковид-19) элдэв бэлтгэлгүйгээр төлөвлөлтөд орох хамтлах, хэдхэн минутад бүтэц бүтэц, өрөөн тутгайгаар хамт хамт бүртгэлтэй хамтлах буюу өрөөн тутгайгаар бүтэц бүтэц 14 өдөр гурван тусгаарлахад бэлэн

ЦАХИМ ШУУДАН



## СУРГУУЛЬ ДАДЛАГЫН НИСЛЭГ ҮЙЛДЛЭЭ

Зэвсэгт хүчний 337 дугаар анги



2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2021 оны 6 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд сургууль дадлагын нислэгийг Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн Ми-171Е

загварын нисдэг тэргээр амжилттай хийж гүйцэтгэлээ. Сургууль дадлагын нислэгийг Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн нислэг эрхэлсэн нэгдүгээр орлогч-нисгэгч, хурандаа Н.Баясгалан удирдан тус

ангийн районд нисгэгч нараар дүүжин, хайрцаг, талбай сонгож буух болон аэродромтой танилцах зэрэг нийт 14.5 цагийн нислэгийг үйлдэж нисгэгчдийн ур чадварыг нэмэгдүүллээ.

Ахлах дэслэгч Д.ЭРДЭНЭСУВД

## ХОГ ЦЭВЭРЛЭХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай рот



Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан “Унасан газар угаасан усаа хайрлан хамгаалъя” уриан

дор Зэвсэгт хүчний 104 дүгээр тусгай ротын бие бүрэлдэхүүн халдвар хамгаалалтын дэглэмийг чанд баримтлан нийгмийн

хариуцлагынхаа хүрээнд Номгон сумын урд хэсгийн газар нутгийг цэвэрлэх ажлыг зохион байгуулав.

Ахмад Э.ЭНХСАРУУЛ

## ХОЛБООЧДОДОО ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 326 дугаар анги



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э. Даваажамц нь цэрэг хүнд байх сэтгэл зүйн их хат, тэсвэр, хатуужил, эр зоригийг

харуулан Зэвсэгт хүчин, харьяа командлал, анги байгууллагынхаа нэр хүндийг өндөрт өргөж яваад талархан 186 ангийн хамт олон “2100

км 2100 төгрөг” уриалга дэвшүүлэн 602100 төгрөгийн хандив үзүүлээ.

Хошууч Т.ЗАЯАНДАРЬ

## ХАР ТЭНГИСТ АНГИЙН БАЙЛДААНЫ УСАН ОНГОЦ, ОРОСЫН УСАН ХИЛИЙГ ЗӨРЧСӨН ТУЛ АНХААРУУЛАХ БУУДЛАГА ХИЙЛЭЭ

Доктор /Ph.D/, хурандаа Р.ЭНХБОЛД



Өнгөрсөн сарын сүүлээр Хар тэнгист эргүүлийн үүрэг гүйцэтгэж байсан английн тэнгисийн цэргийн “Defender” байлдааны усан онгоц, оросын усан хилийг 2 километр гүн газраар нэвтэрч, зөрчил гаргасан тул оросууд радиогоор анхааруулга өгчээ. Гэвч английн усан онгоц чиглэлээ өөрчлөөгүй тул оросын байлдааны усан онгоц 12.06, 12.08 цагт тус тус анхааруулах буудлага хийсэн байна. Үүний дараа 12.18 цагт оросын

1 нэгж “Су-24” бөмбөгдөгч нисэх онгоц английн усан онгоцны замд “ОФАБ-250” загварын 4 ширхэг агаарын бөмбөг хаясан тул английн байлдааны усан онгоц чиглэлээ өөрчилж уг газраас гарчээ.

Энэ хэргээс болж ОХУ-д суугаа Англи Улсын батлан хамгаалахын атташег оросын БХЯ-нд дуудаж уулзан, тодруулга авсан байна. Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр ОХУ-ын талаас анхааруулах буудлага хийсэн гэж мэдээлсэн бол Английн БХЯ

болон “BBC” телевизээр манай байлдааны усан онгоц, оросын хилийг зөрчөөгүй, олон улсын усанд явж байсан, мөн манай усан онгоц руу чиглэсэн буудлага хийгээгүй гэж мэдээлэв. Хар тэнгист сүүлийн жилүүдэд АНУ болон түүний холбоотны байлдааны усан онгоцнууд тогтмол эргүүл хийж байгаа боловч ингэж оросын усан хилийг шууд зөрчсөн тохиолдол ховор гарч байсан юм.

/Эх сурвалж: digitalnewshour.com/

## АВТО ТЕХНИКҮҮДИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

Зэвсэгт хүчний 327 дугаар анги



ЗХЖШ-ын даргын болон ангийн захирагчийн тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн “Удаан хугацааны хадгалалт”-ын авто техникуудийг шилжүүлэн байрлуулж, салбаруудын тайван цагийн орон тооны дутуу техникийг нөхөн хангах, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор ГАЗ-53, ГАЗ-66, ЗИЛ-130, ЗИЛ-131, УРАЛ-375 загварын нэгж авто техникуудийг хүлээлгэн өгөх ажлыг 10 хоногийн хугацаанд амжилттай зохион байгууллаа.

Ахмад Д.ГАНБААТАР

## АМТЛАГЧ АЯНЫГ ӨРНҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл



Нэгтгэлийн ажилтан алба хаагчдын зөвлөлөөс санаачлан зөвлөлийн эмэгтэй гишүүд хугацаат цэргийн алба хаагчдын хоолны амт, чанарт дэмжлэг үзүүлэх зорилгоор “Амтлагч 7 хоног”-ийн аяныг

зохион байгуулж явууллаа. Аянд нийт 50 гаруй ажилтан алба хаагчид хамрагдаж 20 нэр төрлийн 50 гаруй амтлагчийг цуглуулж хүнсний албаны даргад гардуулан өглөө. Тус арга хэмжээг зохион байгуулсан

нь цэргийн гал тогооны хоолны амт, чанарт ихээхэн дэмжлэг үзүүлж тогооч, бэлтгэгч нарын талархлыг хүлээлээ.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ